



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Алтай хотын цогц үйлчилгээний газар” ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/12/-НА-СТА-ААТҮГ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2022 он	Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр	
	Утас: 70483413	Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
	Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг	
	Утас: 70484055	Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn
	Ахлах аудитор: Ж.Бүжинханд	
	Утас: 99177546	Цахим хаяг: Bujinkhandj@audit.gov.mn
	Аудитор	Г.Энхдэлгэр
	Утас: 70484030	Цахим хаяг: Enkhdelgerg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
3. Аудитын тайлан	6
3.1 Ерөнхий зүйл	6
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	6
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	6
3.4 Материаллаг байдал	7
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	7
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	7
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	Error! Bookmark not defined.
3.8 Аудитын гол асуудал	Error! Bookmark not defined.
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	Error! Bookmark not defined.
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	10
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	10
4. Аудитын илрүүлэлт	10
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

тухай хуулийн 13.7, 14 дүгээр зүйлийн 14.4, 20 дугаар зүйлийн 20.2.3, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3, Татварын ерөнхий хуулийн 28.2, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3 дахь заалттай нийцэхгүй бөгөөд үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	-	3,037,973.73
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	2,971,435.73
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	2,971,435.73
31210	Төгрөг	-	2,971,435.73
31213	Арилжааны банк дахь харилцах	-	2,971,435.73
33	АВЛАГА	-	66,538.00
33402	Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	-	66,538.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	-	1,872,911,312.95
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	-	1,872,911,312.95
39100	Газар	-	-
39200	Биет хөрөнгө	-	1,872,911,312.95
39201	Барилга, байгууламж, орон сууц	-	1,492,538,140.21
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	(543,935,236.41)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	-	215,882,222.20
39204	Хуримтлагдсан элэгдэл	-	(58,646,888.80)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	-	300,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-	(242,500.00)
39214	Бусад үндсэн хөрөнгө	-	1,624,363,187.73
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	(857,347,611.98)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	-	1,875,949,286.68
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	2,475,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	2,475,000.00
41400	Урьдчилж орсон орлого	-	2,475,000.00
41440	Бусад урьдчилж орсон орлого	-	2,475,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	-	1,873,474,286.68
51	Засгийн газрын хувь оролцоо	-	1,873,474,286.68
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	-	-
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	-	1,872,911,312.95
51200	Хуримтлагдсан үр дүн	-	562,973.73
51210	Өмнөх үеийн үр дүн	-	-
51220	Тайлант үеийн үр дүн	-	562,973.73
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	-	1,875,949,286.68

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	-	176,698,431.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	49,743,026.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	49,743,026.00
120010	Борлуулалтын орлого (Цэвэр) /ТӨҮГ/	-	49,743,026.00
120011	Борлуулалтын өртөг /ТӨҮГ/	-	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	126,955,405.00
1330	Төсвийн захирагчдаас	-	126,955,405.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	126,955,405.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	-	176,135,457.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	176,135,457.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	176,135,457.27
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	176,135,457.27
210813	Бусад зардал /ТӨҮГ/	-	176,135,457.27
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-	562,973.73
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-	562,973.73
VI-I	Засгийн газрын хувь оролцоо	-	-
VI-II	Хяналтын бус хувь оролцоо	-	-

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	-
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	1,872,911,312.95	-	1,872,911,312.95
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
17	Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	562,973.73	562,973.73
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,872,911,312.95	562,973.73	1,873,474,286.68

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	-	179,173,431.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	179,173,431.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	179,173,431.00
120009	Бусад орлого	-	2,896,000.00
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	-	49,743,026.00
120017	Татаас, санхүүжилтийн орлого /ТӨҮГ/	-	126,534,405.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	176,201,995.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	176,201,995.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	176,201,995.27
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	64,424,989.00
210106	Ажилагчдад төлсөн /ТӨҮГ/	-	64,424,989.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	18,352,887.27
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	-	18,352,887.27
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	25,286,980.00
210301	Гэрэл, цахилгаан	-	25,286,980.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	43,811,218.00
210402	Тээвэр, шатахуун	-	10,931,968.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	-	32,879,250.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	24,325,921.00
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	-	3,679,005.00
210817	Даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	-	-
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	-	20,646,916.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-	2,971,435.73
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	-	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН	-	-
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	-	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	2,971,435.73
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2,971,435.73

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу “Алтай хотын цогц үйлчилгээний газар” ТӨҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж, мөрдөхтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Энхдэлгэр гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

“Алтай хотын цогц үйлчилгээний газар” ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2021 оны 3 дугаар сарын 07-ны өдрийн 5 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

“Алтай хотын цогц үйлчилгээний газар” ТӨҮГ нь Алтай хотын гудамжны гэрэлтүүлэг, гэрлэн дохионы асалт, арчлалт, хамгаалалтыг хариуцах, хөшөө, түүх соёлын дурсгалт газар, ногоон байгууламжийг арчлах, тордох, нийтийн зорчигч тээвэр, такси үйлчилгээг зохион байгуулах зэрэг үйл ажиллагааны чиглэлтэй байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаагаа шинээр эхэлсэн.

Үйлдвэрийн газрын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус үйлдвэрийн газар нь тайлант хугацаанд шинээр үүсгэн байгуулагдсан хэдий ч нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж үйл ажиллагаандаа ашиглаагүй байна. Энэ талаар аудитын тайланд зөвлөмжөөр тусгасан.

Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Алтай хотын цогц үйлчилгээний газар” ТӨҮГ нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлого, үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны орлого, үр дүнгийн тайлангийн нийт зардлын 180.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 3.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 2.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг 2021 оны үзүүлэлтээс тооцсон учраас материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Байгууллагын үйл ажиллагаа

Үйлдвэрийн газрын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг Алтай хотын гудамжны гэрэлтүүлэг, гэрлэн дохионы асалт, арчлалт, хамгаалалтыг хариуцах, хөшөө, түүх соёлын дурсгалт газар, ногоон байгууламжийг арчлах, тордох, нийтийн зорчигч тээвэр, такси үйлчилгээг зохион байгуулах гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд 1 статустай байна. Өмчийн 100 хувийг орон нутаг эзэмшиж байна.

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

“Алтай хотын цогц үйлчилгээний газар” ТӨҮГ-ыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн тэргүүлэгчдийн хурлын 2021 оны 7 дугаар сарын 21-ны өдрийн 53 дугаар тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

ТУЗ-ын бүрэлдэхүүн томилогдоогүй. Байгууллагын ажилчдын цалингийн жишгийг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн тэргүүлэгчдийн хурлын тогтоолоор баталж өгсөн.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд шилжүүлэн авсан бүх хөрөнгийг бүртгэл тооцоонд тусгаж, арчлалт, хадгалалт, хамгаалалтыг хийх арга хэмжээ авсан байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар

хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;"-д заасны дагуу энэ төрлийн зардал гаргаагүй.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн 2021 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн 53 дугаар тогтоолоор тус үйлдвэрийн газрыг үүсгэн байгуулж, бүтэц орон тоо, дүрмийг баталсан.
- Засгийн газрын 43 дугаар "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолоор төсвийн хэмнэлтийн талаар тусгасан.

3.6 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдээгүй, их хэмжээний алдаатай байсныг аудитын явцад залруулж тайлагнасан.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		2,971.4	2,971.4
БХХО			
Авлага		66.5	66.5
Урьдчилгаа			
Бараа материал			
Үндсэн хөрөнгө		1,872,911.3	1,872,911.3
Биет бус хөрөнгө			
Нийт хөрөнгийн дүн		1,875,949.3	1,875,949.3
Өр төлбөрийн дүн			
Богино хугацаат өглөг			
Урьдчилж орсон орлого		2,475.0	2,475.0
Эздийн өмч		1,873,474.3	1,873,474.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн		1,875,949.3	1,875,949.3

Банк дахь мөнгөний үлдэгдэлд харилцах дансанд байгаа 2.97 сая төгрөг байна.

Авлагын үлдэгдэлд НДШ-ийн авлага 0.07 сая төгрөг байна.

Тайлант хугацаанд 51.2 сая төгрөгийн бараа материал бэлтгэж зарцуулсан.

Үндсэн хөрөнгө дансанд 3,333.1 сая төгрөгийн хөрөнгө шинээр бүртгэсэн. Үүнд:

Тус үйлдвэрийн газар нь шинээр байгуулагдсантай холбоотойгоор үйл ажиллагааны чиглэлийн дагуу аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн тэргүүлэгчдийн хурлын 2021 оны 84 дүгээр тогтоолоор Алтай хотын тохижилт үйлчилгээний газраас 77 нэр төрлийн 2,946.7 сая төгрөгийн балансын үнэтэй 1,393.7 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй хөрөнгө, Сум дундынг ойн ангиас 14 нэр төрлийн 129.7 сая төгрөгийн балансын үнэтэй 14.5 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй хөрөнгө, Есөнбулаг сумын Засаг даргын тамгын

газраас 3 нэр төрлийн 202.7 сая төгрөгийн балансын үнэтэй 52.0 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй хөрөнгө, мөн Орон нутгийн өмчийн газраас ирүүлсэн албан бичгийн дагуу шинээр хүлээн авсан Есөнбулаг сумын Солонго хорооллын 1788 айлын гадна инженерийн шугам сүлжээний ажлын гадна гэрэлтүүлгийн 54.0 сая төгрөгийн хөрөнгийг тус тус орлого авч бүртгэлд тусгасан.

Урьдчилж орсон орлого 2.5 сая төгрөг тайлагнасан. Энэ нь Бумбат даваа ХХК-тай хамтран ажиллахаар “Гэрлийн шон суулгах иж бүрэн ажлын хамтран гүйцэтгэгчээр ажиллах” гэрээний дагуу урьдчилж орж ирсэн 2.5 сая төгрөгийг бүртгэсэн.

3.6 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Алтай хотын цогц үйлчилгээний газар” ТӨҮГ-ын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Гэвч үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулаагүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу Нэгдсэн эмнэлгийн 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тухайн байгууллага нь тайлант онд үүсгэн байгуулагдсан хэдий ч цахим хуудсанд цэс нээгдээгүй шалтгаанаар мэдээлэл байршуулаагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилт

Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл болон Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу гүйлгээ бүрт төлбөрийн баримтаар буюу и баримт шивүүлж баримтын бүрдэл болгох үүрэгтэй.

Тайлант хугацаанд 12.5 сая төгрөгийн гүйлгээнд төлбөрийн баримт аваагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Татварын ерөнхий хуулийн 28.2-т “Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ

хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.” Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т “Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ.” гэсэн заалттай нийцээгүй байна.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

“Алтай хотын цогц үйлчилгээний газар” ТӨҮГ-ыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн тэргүүлэгчдийн хурлын 2021 оны 7 дугаар сарын 21-ны өдрийн 53 дугаар тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Аудитад хамрагдаагүй.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Үйлдвэр санхүүжилтын төлөвлөгөө батлуулж, биелэлтийг хангуулсан эсэх

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, бүртгэл хөтлөлтийг стандартын дагуу хөтөлсөн эсэх

Цалингийн тооцоолол, кассын тайлан, шатахууны зарцуулалтыг үзэх нь зүйтэй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 347.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 276.1 сая төгрөгийн алдаа залруулж, 0.2 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 71.4 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмж өгсөн.

4.2.1 Залруулсан алдаа

Санхүүгийн байдлын тайланд хөрөнгийг 269.8 сая төгрөгөөр, авлагыг 0.1 төгрөгөөр, орлого үр дүнгийн тайланд орлогын дүнг 6.3 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.

4.2.2 Төлбөрийн акт

Ажилдчдад 0.1 сая төгрөгийн цалинг илүү, 0.1 сая төгрөгийн цалинг дутуу олгосон байна. олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй бөгөөд үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

Кассанд авч зарцуулсан бэлэн мөнгөнөөс 0.1 сая төгрөг дутагдсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалттай нийцэхгүй бөгөөд үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

4.2.3 Албан шаардлага

Нийгмийн даатгалын тайланд цалинг 0.4 сая төгрөгөөр илүү тайлагнасан нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалт “Ажил олгогч болон энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч нь шимтгэл төлөх талаар дор дурдсан үүрэг хүлээнэ: 1/хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх;” заалттай нийцэхгүй бөгөөд үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-т "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Татварын тодорхойлолтоор 2.3 сая төгрөгийн зөрүү тооцоо татварын цахим системд бүртгэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-т "Аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2-т "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.3-т "Бүх өр төлбөр" заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Арилжааны банкны харилцах данснаас 7.0 сая төгрөгийг бэлнээр авч зарцуулсан, анхан шатны баримттай боловч кассын тайлан гаргаагүй, худалдан авсан 10.9 сая төгрөгийн түлш, шатах тослох материалын тайлан гаргаагүй, жолоочийн тооцооны хуудсыг хангалтгүй бичсэн, тооцооны хуудсыг үндэслэн тооцоо бодоогүй, мөн худалдан авсан 32.9 сая төгрөгийн бараа материалын орлого, зарлагын баримт, шаардах хуудас бүрэн хэдий ч нярвын тайлан гаргаагүй, нягтлан бодох бүртгэлийг хууль, журам, стандартын дагуу хөтлөөгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", УСНББОУС-1-тэй нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Татварын тайланд цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг 5.4 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д "Суутган төлөгч энэ хуулийн 14 дүгээр зүйл, 16.1.2, 16.1.3, 16.1.4, 17.1.1, 18 дугаар зүйл, 19.1.1, 19.1.2, 20.1-д заасны дагуу тодорхойлсон орлогод ногдуулан суутгасан албан татварын улирлын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор өссөн дүнгээр гаргаж, харьяа татварын албанд хүргүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Тус байгууллага нь гүйцэтгэлийн болон үйлдвэр санхүүгийн төлөвлөгөөгүй, дүгнэсэн материалгүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.1.3-т "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах" гэсэн заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Тайлант хугацаанд 12.5 сая төгрөгийн гүйлгээнд төлбөрийн баримт аваагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг

баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ.” гэсэн заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Тухайн байгууллага нь тайлант онд үүсгэн байгуулагдсан хэдий ч цахим хуудсанд цэс нээгдээгүй шалтгаанаар мэдээлэл байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоол “Журам шинэчлэн батлах тухай”-ыг зөрчсөн бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ дээрх хөрөнгийн дүн санхүүгийн тайлан дахь төрийн өмчийн дүнгээс 1,892.9 сая төгрөгөөр зөрүүтэй байгаа нь Улсын бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр 14.2. “Монгол Улсын иргэн, тус улсын нутаг дэвсгэрт оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд энэ хуулийн 6, 7, 8 дугаар зүйлд заасан улсын бүртгэлийн мэдээллийг хуульд заасан хугацаанд улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй.”, Хууль зүй дотоод хэргийн сайдын 2018 оны А/208 дугаар тушаалаар баталсан “Хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрын улсын бүртгэл хөтлөх журам”-ын 8.2.Хуулийн этгээдийн дараах мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг хуульд өөрөөр заагаагүй бол ажлын 15 өдрийн дотор улсын бүртгэлд бүртгүүлнэ:8.2.3.хувь нийлүүлсэн хөрөнгө” гэсэн заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

4.2.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж үйл ажиллагаандаа ашиглаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Стандартын дагуу байгууллагын онцлог, үйл ажиллагаанд нийцүүлж нягтлан бодох бүртгэл, тайлагнал, санхүү, нягтлан бодох бүртгэлийн бусад үйл ажиллагааг тусгаж бодлогын баримт бичиг боловсруулж, мөрдөх.

2 Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тухайн байгууллага нь тайлант онд орон нутгийн төсвөөс татаас санхүүжилт 126.5 сая төгрөг, өөрийн үйл ажиллагааны орлогоос 49.7 сая төгрөг орсон боловч Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгэгдээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Татварын хэлтэст: Хууль эрх зүйн хэрэгжилтийг ханган ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
	“Алтай хотын цогц үйлчилгээний газар” ТӨҮГ	12	347.7	1	276.1	2	0.2	8	58.8	1	0
Дүн		12	347.7	1	276.1	2	0.2	8	58.8	1	0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
	“Алтай хотын цогц үйлчилгээний газар” ТӨҮГ	2	0					1	12.5	1	0
Дүн		2	0					1	12.5	1	0
Нийт дүн		14	347.7	1	276.1	2	0.2	9	71.4	2	0